



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 1/2024

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, 48.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт шилмүүст болон навчит модны үр, мөчир, үржүүлэх "Хүлэмж" худалдан авах ажил, Мод үржүүлгийн газрын усалгааны систем шинэчлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Гишүүд: Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)
Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангуулж хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Б.Янжиндулам)-д даалгасугай.

3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлсэн Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт шилмүүст болон навчит модны үр, мөчир, үржүүлэх "Хүлэмж" худалдан авах ажил, Мод үржүүлгийн газрын усалгааны системийг өмчийн бүртгэлд бүртгэж, ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг сум дундын Ойн ангийн нягтлан бодогч (Д.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

822301461